




ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн
нийгэм, эдийн засгийн
танилцуулга

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2017 / 8



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2018 оны 08 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт**1.1 Хүн ам**

Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 08 сард 899 эх амаржиж, 902 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 73(8.8%)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 72(8.7%)-оор, 264 хүн нас барсан нь 32(13.8%)-оор тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 638 болж өмнөх оны мөн үеэс 40(6.7%)-өөр өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 13.4, нас баралт 3.9 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.6 пунктээр өсч, нас баралт 0.3 пунктээр буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2015-2018 оны 08 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 11 байгаа нь өмнөх оны мөн үеэс 5-аар илүү юм.

**1.2 Эрүүл мэнд**


2018 оны 08 сарын байдлаар 233.5 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар, 11.4 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар тус тус өсч, 7.5 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар буурчээ.

2018 оны 08 сард 1072 эх жирэмсний хяналтанд орсны 88.0 хувь буюу 899 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 13.3 мянган удаа гарсны 2.3 мянга буюу 17.3 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 6.4 хувиар, алсын дуудлага 4.5 хувиар тус тус өссөн байна.

Он гарсаар ослын улмаас 2177 хүн бэртэж, 68 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 339(18.4%)-өөр, нас барсан хүний тоо 9(15.3%)-өөр нэмэгджээ.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 08 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд осол, гэмтэл, хордлого гадны шалтгаант үхэл 25.8 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 24.2 хувь, хавдар 20.1 хувь, хоол шингээх эрхтний өвчин 11.0 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 6.4 хувь, бусад төрлийн өвчин 12.5 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 484 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 48(9.0%)-аар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад вирус гепатит 37.5 хувиар, бусад төрлийн өвчин 59.7 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 08 сарын эцэст 734 болсны 709 (96.6%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 25 (3.4%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 971 (43.0 %) хүнээр буурч, өмнөх сараас 71(10.7%) хүнээр буурсан байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 337 (45.9%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 356 (48.5%) нь Сайншанд суманд, 148 (20.2%) нь Замын-Үүд суманд байна.

Боловсролын түвшинг харахад 66.2 хувь нь бүрэн дунд, 15.5 хувь нь дээд, 5.4 хувь нь бүрэн бус дунд, 6.1 хувь нь техник болон мэргэжлийн, 3.4 хувь нь тусгай дунд, 2.3 хувь нь боловсролгүй, 1.0 хувь нь бага боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2018 оны 08-р сард



Хөдөлмөрийн хэлтэст он гарсаар 1642 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 314 иргэн ажилд зуучлагдан орж, 86 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 415 ажлын байрны 53 (12.8%) нь үйлчилгээний, 48 (11.6%) нь төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, 157 (37.8%) нь бусад салбарын, 157 (37.8%) нь уул уурхайн олборлолтын салбарын захиалга байна. Ажил хайгч 314 иргэн хөдөлмөрийн байгууллагаар дамжуулан ажилд зуучлуулан орсны 121 (38.5%) нь эмэгтэйчүүд байна

Зураг. Бүртгэлгүй ажилгүй иргэд сумаар

Зураг. Шинээр ажлын байранд орсон салбараар






1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 08 сард 21100.2 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2985.6(16.5%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 2985.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 2510.0(23.3%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 418.5(23.5%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 284.7(23.3%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2018 оны 08 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 29586.5 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 3638.2 (14.0%) сая төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 21428.7(72.4%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4299.8(14.5%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1686.7(5.7%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1642.9(5.6%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 528.4(1.8%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг







Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 08 сард нийгмийн халамжийн сангаас 22506 иргэнд 5378.7 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 5849 (35.1%)-өөр, олгосон тэтгэвэр тэтгэмж 1692.7 (45.9%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж өсөхөд цалинтай ээж хөтөлбөрт 3769 иргэнд 1189.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2018 онд 1353 хүн хамрагдсан нь өмнөх оноос 27 (2.0%)-ээр, олгосон тэтгэвэрийн хэмжээ 274.8 (22.2%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжид 1067 иргэнд 505.5 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 993 иргэнд 399.6 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 7934 иргэнд хамруулж 656.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн бусад халамжийн шаардлагатай иргэнд үзүүлэх тусламжийг 11159 иргэнд 2305.4 сая төгрөг олгосон байна.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/





1.5 Гэмт хэрэг


Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 08 сарын байдлаар 353 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 81 хүн гэмтэж, 15 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 108(20.7%)-аар, нас барсан хүний тоо 3(16.7%)-аар, гэмтсэн хүний тоо 48(37.2%) -аар буурсан байна.

Төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийтийн албан ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг нэмэгдэж бусад төрлийн гэмт хэрэг буурчээ.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 43.9 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 24.6 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 9.3 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг, 4.8 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 41 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 67(62.0%) -оор буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Өргөн, Хатанбулаг, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад буурч, Даланжаргалан, Иххэт, Мандах сумд өмнө оны мөн үеийнхтэй адил, бусад сумдад гэмт хэргийн тоо нэмэгдсэн байна


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 641.5 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2421.4(79.0) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 374.5(58.4%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 98(27.8%) нь гэр сууцандаа, 48(13.6%) нь гудамж олон нийтийн газарт, 41(11.6%) нь согтуугаар, 53(15.0%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 17(4.8%) бүлэглэн, 124 (35.1%) нь шөнийн цагаар /22.00-06.00 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 896 хүн эрүүлжүүлэгдэж, 185 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 08 сар




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 947.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 203.2(27.3%) тэрбум төгрөгөөр, цэвэр зарлага 897.3 тэрбум төгрөг болж 185.5(26.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2017- 2018 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2017-2018 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 92.8 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1264.4 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1360.8 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 6.9 (10.5%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 18.6 (25.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 08 дугаар сарын эцэст 3448.3 сая төгрөг болж, өмнөх сараас 507.9(17.3%) сая, өмнөх оны мөн үеэс 377.4 (12.3%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.4 хувийг эзэлж, өмнөх сараас 0.1 пунктээр нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл 08 дугаар сарын эцэст 8290.8 сая төгрөг болж өмнөх сараас 135.4(1.6%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 176.7 (2.2%) сая төгрөгөөр нэмэгдсэн. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.08 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.08 сард



2.2 Орон нутгийн төсөв

2018 оны 08 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 17942.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 101.2 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 25.0 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 75.3 хувийг татварын, 24.7 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2018 оны 08-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 3525.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 882.2 (33.4%) сая.төг-өөр нэмэгдэж, тухайн оны төлөвлөгөөнөөс 1491.5 (73.3%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.


Хэрэглээний үнийн индекс 2018 оны 08 дугаар сард өмнөх сараас 0.6 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сараас 0.6 хувиар буурахад: хүнсний бараа, ундаа усны бүлэг 4.1 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисны бүлэг 2.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 1.7 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 2.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 1.0 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 08 дугаар сарын өөрчлөлт, өмнөх сартай харьцуулсанаар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 08 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 08 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 71.4 хувь буюу 604.0 мянган толгой мал төллөж, төл бойжилт 97.5 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 33.9(5.9%) мянган толгойгоор, төл бойжилт 20.7(3.6%) мянган толгойгоор илүү юм.

Эхний 8-н сарын байдлаар 8617 том мал хорогдож өмнө оны мөн үеэс хорогдол 6.5(4.1 дахин) мянган толгойгоор нэмэгдсэн байна. Хорогдол нэмэгдэхэд Дэлгэрэх, Иххэт сумдын нутаг дэвсгэрээр 4-р сард нойтон цас орж, хүчтэй цасан шуурга шуурч байгалийн онц аюултай үзэгдэл болж, Дэлгэрэх суманд 2.2 мянган толгой мал, Иххэт суманд 2.2 мянган толгой мал, Даланжаргалан суманд 1.2 мянган толгой мал хорогдсон нь голлон нөлөөлсөн байна.

2018 оны 8-р сард 40.8 га талбайгаас 66.2 тонн ургац хураан авсан нь нийт тариалсан талбайн 45.5 хувийг эзэлж байна. Хураан авсан ургацыг өмнө оны мөн үетэй харьцуулахад 17.8(36.8%) тонноор нэмэгдсэн.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 08-р сард хонины арьс дундаж үнэ 3000 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2500(5.0 дахин) төг-өөр нэмэгдсэн байна. Эр хонь 100.0-170.0 мян.төг, эр ямаа 80.0-130.0 мян.төг-өөр худалдаалагдаж байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 08 сард аж үйлдвэрийн салбарт 134240.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 196299.4 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн



үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 44659.9(49.9%) сая төгрөгөөр, борлуулалт 50949.9(35.1%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2018 оны эхний 8 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 49.9 хувиар өсөхөд уул, уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 17899.3 сая төгрөгөөр, боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 26429.4 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 3.2 хувийг төрийн, 96.8 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 3.2 хувь, компани 96.5 хувь, өрхийн аж ахуй 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал дулаан 4.0 мян.ккал-аар, сувагжуулалт 75.2 мян.м3-ээр, ус түгээлт 38.6 мян.м3-аар, нарийн боов 13.0 тонноор, бялуу 0.1 тонноор, нүүрс 102.2 мян.тонноор, вакуум цонх 719.8 м2-аар, цемент 366.5 мян.тонноор, модон эдлэл 20928.4 мян.төгрөгөөр, дээл 134 ширхэгээр, жижиг оёдол 1583.8 мян.төгрөгөөр тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин Цаг уур

2018 оны 08 дугаар сарын дундаж агаарын температур Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Замын-Үүд сумдад 23.5-23.7 хэм дулаан, бусад сумдын нутгаар 20.6-22.8 хэм дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө 33-37 хэм дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Улаанбадрах суманд олон жилийн дунджаас 1.3 градусаар хүйтэн, Өргөн, Эрдэнэ, Алтанширээ, Дэлгэрэх сумдад ОЖД-ийн орчим, бусад сумдын нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 7-13 хэм дулаан, өдөртөө нийт нутгаар 55-61 хэм дулаан байв.

08 дугаар сард нийт сумдын нутгаар 7-24 өдөр бороо орлоо. Сарын нийлбэр хамгийн их бороо Айраг суманд 144.0 мм, Улаанбадрах суманд 85.7 мм, бусад сумдын нутгаар 14.2-77.3 мм бороо орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундажтай харьцуулахад: Хөвсгөл, Иххэт сумдад ОЖД-аас бага, Эрдэнэ суманд ОЖД-ийн орчим, бусад сумдын нутгаар ОЖД-аас ахиу байлаа.

Энэ сард салхины хамгийн их хурд Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад 16-23 м/с хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Замын-Үүд, Эрдэнэ, Хөвсгөл сумдад 10-11, Сайншанд суманд 8, Мандах, Дэлгэрэх сумдад 5, Алтанширээ суманд 1, бусад сумдын нутгаар салхины хурд 10м/с хүрээгүй байна.



АГУУЛГА

II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл (Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Эрүүл мэнд
- 1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
- 1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар

Хоёр. Хөдөлмөр эрхлэлт

- 2.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
- 2.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар
- 2.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
- 2.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
- 2.5 Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
- 2.6 Шинэ ажлын байранд орсон иргэн, эдийн засгийн салбарын ангиллаар

Гурав. Нийгмийн даатгал, халамж

- 3.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
- 3.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
- 3.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

Дөрөв. Гэмт хэрэг

- 4.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
- 4.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар

Тав. Мөнгө, зээл

- 5.1 Мөнгөн гүйлгээ, зээл
- 5.2 Хадгаламж, зээл, сумаар, сарын эцэст

Зургаа. Орон нутгийн төсөв

- 6.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
- 6.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
- 6.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
- 6.4 Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр

Долоо. Үнэ

- 7.1 Хэрэглээний үнийн индекс
- 7.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф
- 7.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар

Найм. Хөдөө аж ахуй

- 8.1 Мал төллөлт, төл бойжилт
- 8.2 Том малын зүй бус хорогдол
- 8.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр
- 8.4 Малын үнийн судалгаа, сумаар
- 8.5 Тариалсан талбай, сумаар, сарын эцэст

Ес. Аж үйлдвэр

- 9.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
- 9.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа
- 9.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар
- 9.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр

Арав. Байгаль орчин

- 10.1 Цаг уурын үзүүлэлт

Тэмдэглэлийн тайлбар :

- (,,) - тухайн тоо, баримт байхгүй
- (0) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
- (x) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
- (.) - мэдээлэгдэх хугацаа болоогүй

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2018 ОНЫ 08 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2018 - 2017	2018
1. Бэлэн хүн ам	мянган хүн	63.1	66.6	68.2	68.8	0.6	100.9
- Төрсөн хүүхдийн тоо*	тоо	1058	973	830	902	72	108.7
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	199	243	232	264	32	113.8
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	859	730	598	638	40	106.7
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	10	9	6	11	5	183.3
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	8.4	9.2	7.2	12.2	5.0	168.7
2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	568	1427	496	342	-154	69.0
- 10000 хүнд ногдох	тоо	17.9	54	73	50	-23	69.0
3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	916	1 055	1 705	734	- 971	43.0
- Үүнээс эмэгтэй	тоо	537	561	841	337	- 504	40.1
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	279	265	402	170	- 232	42.3
4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	505	284	302	213	-89	70.5
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	505	148	302	87	-215	28.8
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	112	0	126	126	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	393	452	445	353	-92	79.3
- 10000 хүнд ногдох ***	тоо	94	106	104	82	-22	78.9
6.Бойжиж буй төл, мян толгой	толгой	495055	466863	571231	591946	20715	104
- Унага	толгой	14239	11609	6342	6512	170	103
- Тугал	толгой	13384	11729	18331	19003	672	104
- Ботго	толгой	5227	5931	13737	15858	2121	115
- Хурга	толгой	237702	236137	283809	292632	8823	103
- Ишиг	толгой	224503	201457	249012	257941	8929	104
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	6269.0	9249.1	89580.5	134240.4	44659.9	149.9
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	5876.5	6242.1	145349.5	196299.4	50949.9	135.1

* - 2015, 2016, 2017 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 08 сарын эцэст

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-VIII	2018 I-VIII	Өсөлт	
		Тоо			Хувь
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	228.9	233.5	4.6	102.0
2. Ор хоног	мян.хүн	76.2	81.5	5.3	107.0
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	7.7	7.5	-0.2	97.4
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	10.7	11.4	0.7	106.5
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	12.5	13.3	0.8	106.4
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.2	2.3	0.1	104.5
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1838	2177	339	118.4
Үүнээс: нас баралт	хүн	59	68	9	115.3
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1050	1072	22	102.1
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	912	943	31	103.4
8. Амаржсан эх	хүн	826	899	73	108.8
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	1	3	2	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	6	11	5	183.3

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 08 сарын эцэст

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5
				хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүртэл насны эндсэн хүүхэд
Тоо					
Дүн	899	0	902	11	3
Айраг					
Алтанширээ	1				
Даланжаргалан					
Дэлгэрэх	1		1		
Иххэт	1		1		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах				1	
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	1		1		1
Эрдэнэ	3		3	1	
Сайншанд	720		722	6	
Замын - Үүд	171		173	3	2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 08 сарын эцэст

Үзүүлэлт	2017 I-VIII	2018 I-VIII	Өсөлт	
	тоо			хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	532	484	-48	91.0
Вируст гепатит	8	5	-3	62.5
Сүрьеэ	61	68	7	111.5
Тэмбүү	67	75	8	111.9
Заг хүйтэн	86	130	44	151.2
Трихоминиаз	54	61	7	113.0
Цусан суулга	23	51	28	221.7
Бусад	233	94	-139	40.3

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

390
90



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 08 сарын эцэст

Боловсролын түвшингээр	2015.VIII	2016.VIII	2017.VIII	2018.VIII	2018.VIII 2015.VIII	2018.VIII 2017.VIII
	хүний тоо				хувь	
ДҮН	916	1 055	1 705	734	80.1	43.0
Үүнээс: Эмэгтэй	537	561	841	337	62.8	40.1
Магистр, доктор	5	11	8	0	0.0	0.0
Дээд боловсролтой	252	277	388	114	45.2	29.4
Тусгай дунд	123	115	159	25	20.3	15.7
Техник мэргэжлийн	106	116	158	45	42.5	28.5
Бүрэн дунд	314	376	781	486	154.8	62.2
Бүрэн бус дунд	79	125	165	40	50.6	24.2
Бага	28	26	23	7	25.0	30.4
Боловсролгүй	9	9	23	17	188.9	2.2 ²

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 08 сарын эцэст

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2017.VIII	2018.VIII	2017.VIII	2018.VIII	2017.VIII	2018.VIII
ДҮН	1705	734	217	314	513	1642
Айраг	115	57	31	29	40	128
Алтанширээ	19	12	5	9	15	65
Даланжаргалан	86	18	8	22	32	63
Дэлгэрэх	22	12	12	4	13	17
Иххэт	31	33	1	18	14	81
Мандах	67	15	9	55	5	89
Өргөн	77	14	23	22	74	58
Сайхандулаан	38	10	4	4	13	26
Улаанбадрах	38	15	9	36	41	71
Хатанбулаг	37	10	4	8	8	52
Хөвсгөл	21	2	15	12	16	23
Эрдэнэ	31	32	5	4	15	48
Сайншанд	796	356	59	71	143	671
Замын - Үүд	327	148	32	20	84	250

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 08 сарын эцэст

Салбарын ангилал	2017.VIII	2018.VIII
	Тоо	
Бүгд	384	415
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	10	10
Уул уурхай олборлох аж үйлдвэр	216	157
Боловсруулах үйлдвэрлэл	9	5
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1	4
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2	7
Барилга	1	48
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ		1
Тээвэр агуулахын үйл ажиллагаа		16
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		1
Мэдээлэл, холбоо	1	
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3	13
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		2
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	39	48
Боловсрол	22	15
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	17	25
Урлаг, үзвэр,тоглоом наадам	7	9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	56	53
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		1

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 08 сарын эцэст

Үзүүлэлт	2017. VIII	2018. VIII
	Тоо	
Бүгд	384	415
Менежер	10	3
Мэргэжилтэн	82	92
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	42	44
Контор, үйлчилгээний ажилтан	13	14
Худалдаа, үйлчилгээний ажилтан	51	33
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	3
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	48	24
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	80	69
Энгийн ажил мэргэжил	54	123
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	3	10

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 08 сарын эцэст

Үзүүлэлт	2017. VIII		2018. VIII	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	Тоо		Тоо	
Бүгд	217	104	314	121
Менежер	9	2	3	2
Мэргэжилтэн	30	24	49	32
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	23	18	29	17
Контор, үйлчилгээний ажилтан	9	8	16	10
Худалдаа, үйлчилгээний ажилтан	41	28	28	18
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	0	1	
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	15	2	16	3
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	53	6	51	10
Энгийн ажил мэргэжил	33	15	112	25
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	3	1	9	4

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 08 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	Тоо			
Бүгд	213	77	87	126
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2		2	
Уул уурхай олборлолт	38	12	20	18
Боловсруулах үйлдвэрлэл	10	6	2	8
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга	45	10	34	11
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	27	8	12	15
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	31	12	1	30
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	16	13		16
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1		1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	10	2	5	5
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	26	8	3	23
Боловсрол	1	1	1	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	5	5	5	
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1		1	
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 08 сарын эцэст

Үзүүлэлт	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I-VIII
	2017 I-VIII	2018 I-VIII	2017 I-VIII
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	18 114.6	21 100.2	116.5
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	10 765.7	13 275.7	123.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 220.0	1 504.7	123.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн	3 857.2	3 512.1	91.1
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	1 780.2	2 198.7	123.5
Ажилгүйдлийн даатгалын сангийн	491.5	609.0	123.9
Нийгмийн даатгалын сангийн зарлага	25 948.3	29586.5	114.0
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	18 349.1	21 428.7	116.8
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 376.4	1 686.7	122.5
Эрүүл мэндийн даатгалын сангийн	4 093.0	4 299.8	105.1
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	1 507.2	1 642.9	109.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	622.6	528.4	84.9

** - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 08 сарын эцэст

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2017 I-VIII	2018 I-VIII	2018 I-VIII / 2017 I-VIII
1. Заавал даатгуулагч хүний тоо	тоо	15736	16578	105.4
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	тоо	7701	8460	109.9
Төсөвт байгууллага	тоо	8035	8118	101.0
2. Олгосон тэтгэвэр	сая төгрөг	18878.0	21971.8	116.4
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	сая төгрөг	13806.4	15966.6	115.6
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	сая төгрөг	2078.8	2477.0	119.2
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	сая төгрөг	955.5	1092.2	114.3
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	сая төгрөг	566.5	580.0	102.4
Цэргийн тэтгэвэр	сая төгрөг	1470.8	1856.0	126.2

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 08 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2018 I- VIII	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I- VIII
	2017 I-VIII	2018 I-VIII	2017I-VIII	2017 I- VIII	2018 I-VIII	2017 I- VIII
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	16657	22506	135.1	3686031.8	5378719.7	145.9
1. Халамжийн тэтгэвэр	1326	1353	102.0	1236675.9	1511494.9	122.2
Ахмад настны тэтгэвэр	53	59	111.3	57010.4	64616.3	113.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1273	1294	101.6	1179665.5	1446878.6	122.7
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1153	1067	92.5	441949.6	505462.7	114.4
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	1073	1004	93.6	409195.5	473725.8	115.8
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	52	51	98.1	24547.4	26950.0	109.8
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	6	85.7	2536.5	3114.0	122.8
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	12	5	41.7	4524.6	1608.9	35.6
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	9	1	11.1	1145.6	64.0	5.6
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	998	993	99.5	330190.0	399591.2	121.0
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	362	234	64.6	193928.4	256171.2	132.1
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	595	711	119.5	127061.6	82260.0	64.7
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	37	4	10.8	3600.0	360.0	10.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	1	10	10 ²	2000.0	20000.0	10 ²
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	2	11	4.5 ²	2400.0	13200.0	4.5 ²
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	1	11	10 ²	1200.0	13200.0	10 ²
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн		12			14400.0	
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал						
5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	6248	7934	127.0	656717.6	656726.7	100.0
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3677	3499	95.2	183713.6	174162.7	94.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	231	182	78.8	48300.8	59366.6	122.9
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт		2896	0.0		250139.0	
Банкны шимтгэл					3047.8	
